

1. Дан хөгжмийн зохиолын хамгийн том төрөл юу вэ? Зөвийг сонгоно уу.
 a. Дуурь b. Симфони c. Бүжгэн жүжиг d. Аялгуу
2. Сонгодог симфони хэзээ үүссэн бэ?
 a. XVII зууны 2-р хагас b. XVIII зууны 2-р хагас
 c. XIX зууны 2-р хагас d. XVI зууны 2-р хагас
3. Шинэ төрлийн симфонийг үндэслэгчдийг нэрлэнэ үү?



4. Сонгодог симфони хэдэн ангитай вэ?
5. Симфонийн анги тус бүрийн онцлогийг харгалзуулаарай.

1-р анги	Бүжгийн цоглог шинж төрхтэй бөгөөд ард түмний аж амьдралын нэгээхэн зураглал буюу хүний хөгжил баясал, бүжиг наадам ололт амжилт ахуй байдлын олон талыг илэрхийлдэг.
2-р анги	Хөгжил хөдөлгөөнтэй, идэвхитэй хурдтай байдаг. Учир нь энэ ангид аливаа үзэгдлийг хөгжил хөдөлгөөн зөрчил дунд дүрсэлдэг.
3-р анги	Өмнөх ангиудад өгүүлснийг нэгтгэн дүгнэж бататгасан хэсэг.
4-р анги	Удаан байх бөгөөд симфонийн уянгын төв, гүн бодол бясалгалын шинжтэй. Тодруулбал гол баатрын дотоод сэтгэхүйг илэрхийлдэг.

6. Хөгжмөө сонсоод “Миний эх орон” 4 ангит симфони бүтээлийн хэддүгээр анги байна вэ? Тохирохыг сонгоорой.


 - a. 1-р анги Хувьсгалын өмнөх Монголын ард түмний гаслант амьдрал,эрх чөлөөний төлөө хийсэн шударга тэмцлийг дүрслэн харуулсан.
 - b. 2-р анги Эрх чөлөөгөө олж авсан ард түмний жаргалант амьдралыг “Цомбон туурайтай хүрэн” дууны тайван чөлөөтэй удаан уянгалаг аялгуугаар дүрсэлсэн.
 - c. 3-р анги Эрх чөлөөгөө олж авсан ард олон уламжлалт баяр наадмаа хийн цэнгэн баясаж буйг симфонийн уламжлалт “Скерцо” хэмээх цоглог сэргэлэн хөгжмөөр дүрсэлсэн.
 - d. 4-р анги Шинэ нийгмийг бүтээн байгуулж буй ард түмнийхээ хүсэл тэмүүлэл, гэрэлт ирээдүйг сүр жавхлантай илэрхийлнэ

7* “Миний эх орон” симфони бүтээлийн хэсгээс сонсоод агуулга, дүрд тохирохыг сонгоорой.


Анхаарах зүйл: 3-Р АНГИЙН ХЭСГЭЭС СОНСГОХ



8. Симфони хөгжмийн зэмсгийн төрлүүдийг бүлэглээрэй.



9. Ноот бичлэгийг ажиглаад хөгжмөө сонсоорой. Эрийн гурван наадмын төрлүүдийг хөгжимд хэрхэн дүрсэлсэн бэ? Аялгууны шинж төрхөд тохирох зураглалыг харгалзуулаарай.



10. Б.Бриттен "Залуу сонсогчдод зориулсан найрал хөгжмийн танилцуулга" хувилбар аязыг сонсоорой. Симфони найрал хөгжмийн ямар төрөл вэ? Хөгжмийн зэмсгийн өнгө аясад тохирохыг сонгоорой.

-

-

